

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ ТҮҮНД КИОТОГИЙН ПРОТОКОЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Ц. Жигмэддорж *

Хүний үйл ажиллагаа өргөжих тусам байгаль орчин доройтох, экосистем бусных, ургамал амьтны олон төрөл мөхөх, зэрлэг амьтдын амьдрах орчин устаж мөхсөөр байна. Хэдий бид байгалийн гамшиг гэж ярьдаг ч үнэндээ бид байгальдаа асар богинохон хугацаанд их хэмжээний гамшгийг өөрсдөө бий болгоод байна. Шинжлэх ухаан, техник, технологийн эрчимтэй хөгжлийн өнөө үед экологийн судлах зүйлийн агуулга гүнзгийрч, шийдвэрлэх асуудлын цар хүрээ улам бүр өргөжиж, хүн төрөлхтнийг нийтэд нь хамарсан асуудал болоод цөөхөн жил өнгөрч байна.

Энэхүү асуудлууд нь ерөнхийдөө:

- байгалийн баялгийн зохистой ашиглалт,
- нэгэнт алдагдсан экологийн тэнцвэрийг буцаан нөхөн сэргээх,
- цаашид нэмж экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх явдал юм.

Хүн төрөлхтөн эдгээр асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлсээр ирсэн бөгөөд олон улсын хүрээнд тэр тусмаа урд нь төдийлөн анхаарагддаггүй байсан экологийн эрх зүйг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай тулгарсан юм

Одоогоос 36 жилийн өмнө 1972 онд хүн төрөлхтөн Шведийн Стокгольм хотноо нэгэн дээвэр доор цугларан хуралдсан юм. НҮБ-ээс эрхлэн Стокгольм хотод олон улсын анхны Бага хурлыг “Байгаль орчин ба хөгжил” сэдвээр зохион байгуулж, улс орон бүрээс байгаль хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах үйл ажиллагаандаа удирдлага болговол зохих 26 зүйлийн зарчмыг тодорхойлсон Тунхаглал баталжээ¹. Дэлхийн улс орнуудын төр засгийн тэргүүнүүд оролцсон энэхүү хурлаар *нэгдүгээрт*, хүрээлэгч орчны доройтлын асуудалд хариу өгөх зайлшгүй шаардлагатай болсныг хүлээн зөвшөөрчээ; *хоёрдугаарт*, нийгэм-экологийн хөгжил зөвхөн хөгжилтэй орнуудад төдий бус хөгжиж байгаа орнуудад нэгэн адил хурцадсан гэдгийг зөвшөөрсөн; *гуравдугаарт*, байгалийн нөөцийг оновчтой ашиглаж, байгаль хамгаалах салбарын олон улсын стратегийг боловсруулан батлав.

Улмаар 6 дугаар сарын 16-нд хүнийг хүрээлэн буй орчны асуудлаарх Бага хурлын Тунхаглал баталжээ. Энэхүү тунхаглалыг хэрэгжүүлэх “Экологийн арван жил”-ийг зарласан. Стокгольмын Тунхаглалд байгаль орчны эрх зүйд шууд хамааралтай заалт орсон. Тухайлбал:

а) улс гүрэн НҮБ-ын дүрэм болон хүрээлэн буй орчны талаарх өөрийн бодлогын дагуу байгалийн баялгаа ашиглах бүрэн эрхийг нотолсон;

* МУИС, ОУХС-ийн докторант

¹ П.Очирбат, Ш.Баясгалан, Б.Чинзориг. Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ., 2004, 20 дахь тал

б) үүний хамт бүх улс гүрэн өөрийн нутаг дэвсгэр ба хяналтдаа байлгадаг газарт дээрх зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаа нь бусад орны, мөн үндэсний хязгаарын гаднах хүрээлэн орчинд хохирол учруулахгүй байхыг хариуцах үүрэгтэйг заасан (эдгээр хоёр заалтыг Стокгольмын 21 дүгээр зарчим гэж нэрлэсэн);

в) улс гүрнээс хилийнхээ гаднах хүрээлэн буй орчинд хохирол учруулсны төлөө хүлээх хариуцлага, төлбөрийн талаарх олон улсын эрх зүйг хамтын хүчээр боловсруулан мөрдөхийг уриалсан (үүнийг Стокгольмын 22 дугаар зарчим гэж нэрлэсэн);

г) хүрээлэн орчныг хамгаалах, сэргээх хэрэгт улс гүрнүүд хамтран ажиллах ёстойг заасан;

д) өнөөгийн ба хойч үеийнхний ашиг тусын төлөө хүрээлэн орчныг хамгаалах, сайжруулах нь бүх нийтийн ариун үүрэг болохыг тогтоосон;

е) хөгжлийн ба хүрээлэн орчны бодлого нь хоорондоо нягт авцалдаатай байх гарцаагүй шаардлагатайг цохон тэмдэглэсэн².

Энэхүү зарчмын асуудал, тунхаглалд тусгагдсан зарчмууд нь бүх дэлхий нийтийг “экологийн сүйрэл”-ийн эсрэг хамтран тэмцэхийн уриалга, хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд ихээхэн эрч нэмсэн, экологийн эрх зүйн шинэчлэл болсон юм.

Стокгольмоос зарласан “Экологийн арван жил”-ийн хугацаанд олон чухал гэрээ, актууд батлагдаж байсан. 1982 онд уг тунхаглалын хүрээнд гарсан ахиц хөгжлийн гол үр дүнг хэлэлцээд Ерөнхий Ассамблейгаас “Байгалийн талаарх Дэлхийн Харти” баталсан. Энэ Харти нь хүрээлэн буй орчны эрх зүйн үзэл баримтлалын хөгжилд шинэ алхам болсон гэж мэргэжилтнүүд тооцдог. Хартид Стокгольмын тунхаглалыг дэмжин нотлохын хамт байгаль орчныг ариглан хамгаалах талаар улс гүрэн, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллага, хувь хүмүүс, хүн амын бүх давхарга хувь нэмрээ оруулах үүрэгтэйг онцлон заасан.

1972 онд хэлэлцсэн Стокгольмын асуудлын үр дүнг 1982 онд хэлэлцээд дахин арван жилээр сунгаж 1992 онд дахин хэлэлцэж, байгалийн нөөцийг оновчтой ашиглах, байгаль хамгаалах салбарт гарсан ахиц өөрчлөлтийг дүгнэх, нийгэм-экологийн цаашдын хөгжлийн чигийг тодорхойлохоор дэлхийн хамтын нийгэмлэг тохиролцсон байна.

Тэр дагуу 1992 онд Рио Де Жанейро хотноо хуралдсан “Байгаль орчин ба хөгжил” НҮБ-ын Бага хурлаар экологийн 20 жилийн (1972-1992) дүнг гаргаж, экологийн холбогдолтой хэд хэдэн чухал баримт бичиг, ХХI зууны хөгжлийн хөтөлбөрийг хэлэлцэн баталжээ. Рио-92 таван чухал баримт бичиг баталсны дотор:

- Рио-Де-Жанейрогийн Тунхаглал. Энэхүү тунхаглал нь хүний сайн сайхан амьдралыг хангахад улс орнуудын үүрэг хариуцлагын 27 зарчмыг тодорхойлсон.
- ХХI зууны хөгжлийн хөтөлбөр. Иргэншлийг тогтвортой хөгжлийн түвшинд хүргэх арга хэмжээний системийг тодорхойлсон дэлгэрэнгүй хөтөлбөр.

² М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. УБ., 1999, 275 дахь тал

- Цаг уурын өөрчлөлтийн тухай конвенци буюу “Хүлэмжийн хий”-г тогтворжуулах хөтөлбөр.
- Биологийн төрөл зүйлийн тухай конвенци.
- Ойн талаар баримтлах зарчмын тухай мэдэгдэл зэрэг болно³.

Эдгээр баримт бичиг болон Рио-Де-Жанейрогийн бага хурлаар шийдсэн гол асуудлууд нь:

Нэгдүгээрт, хэдийгээр дэлхийн хамтын нийгэмлэгээс байгаль хамгаалах, байгалийн баялгийн ашиглалтыг оновчлох талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа боловч манай гаригийн байгаль нийгмийн систем бүхэлдээ тогтворжиж чадахгүй байгаад анхаарал татахгүй байх үндэсгүй юм. Түүгээр ч барахгүй “экологийн 20 жилийн дотор даян дэлхийн экосистемийн доройтол улам нэмэгдсэн байна”. Цаашилбал өнөөгийн хөгжлийн хэв янзыг хэвээр хадгалвал нийгэм-экологийн зөрчлийг улам хурцатгаж хүний амьдралын нөхцлийг аюултай байдалд хүргэж болзошгүй гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Хоёрдугаарт, иргэншлийн хэрэглээний өсөлт, сав шимийн байгалийн нөөцийн чадавхийн хязгаарлагдмал байдал хоёрын зөрчил; хөгжилтөй болон хөгжиж байгаа орнуудын хэрэглээний түвшний хэт ялгаатай байдал зэрэг өнөөгийн дэлхий дахины хөгжлийн нийтлэг зөрчил хадгалагдсаар байгааг цохон тэмдэглэжээ. Барууны орнууд “Туравдахь ертөнцийн” хөгжлийн шинэ түвшинд хүрэх эрмэлзлийг дэмжихээ нотолсон байна.

Гуравдугаарт, барууны олонх орны хөгжлийн загварыг дэлхийн хамтын нийгэмлэгийн хэтийн хөгжилд бүхэлд нь хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлт хийсэн байна. Энэхүү загвар дэлхийн экосистем рүү гүнзгий нэвтэрснээр сав шимийг аюултай өөрчлөлтөд хүргэж болзошгүй гэж үзсэн байна.

Дөрөвдүгээрт, байгаль нийгмийн дөхөж байгаа аюулыг даван туулахад чиглэгдсэн гол стратеги нь тооны үзүүлэлтээс чанарын өсөлтөнд шилжих иргэншлийн хөгжлийн шинэ загварыг дэвшүүлжээ.

Тавдугаарт, дэлхийн хамтын нийгэмлэгийг бүхэлд нь (эдийн засгийн, нийгмийн, санхүүгийн, зохион байгуулалтын) болон хүн амын янз бүрийн хэсгийг (аж үйлдвэрийн, ажил хэргийнхний хүрээнд ба хөдөө аж ахуйнхан, эрдэмтэд гэх мэт) тогтвортой хөгжлийн замд хүргэх арга хэмжээний системийг дэвшүүлж тавьсан байна.

Зургадугаарт, дэлхийн улс орон бүр өөрийн онцлогт тохирсон тогтвортой хөгжлийн үндэсний стратегийг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Рио-Де-Жанейрогоос гарсан хоёр суурь конвенци болох “Биологийн төрөл зүйлийн тухай” ба “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” конвенциудад 1992 онд 150 гаруй улс гүрэн нэгдэн орж олон улсын хамтын ажиллагааг явуулах зарчим, хэм хэмжээг тодруулан, хөгжиж байгаа орнуудын эдийн засаг, санхүүгийн зэрэг бэрхшээл, зүй ёсны ашиг сонирхлыг илүү ойлгож нэлээд хэмжээгээр бодолцсон заалт оруулсан нь олон улсын эрх зүй улмаар экологийн эрх зүйд шинэ уур амьсгалыг тусгасан дэвшилттэй зүйл болсон юм.

“Биологийн төрөл зүйлийн тухай” конвенцийн зорилго нь амьтан, ургамлын төрөл зүйлийг хадгалж, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг зохистой

³ Монгол улсын Тогтвортой хөгжил” төсөл хэрэгжүүлэх алба. “Хүрээлэн Буй Орчин, Хөгжил”. Рио-де-Жанейрогийн Тунхаглал.

ашиглах замаар генетикийн нөөцийг шударга бөгөөд тэгш эрхийг баримтлан хуваалцаж байх, дэлхийн экосистемийг хамгаалах дэглэмийг тогтооход оршиж байгаа юм. Харин “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” конвенцийн зорилго нь “хүлэмжийн хийн” агаар дахь хуримтлалыг дэлхийн уур амьсгалын системд осолтой өөрчлөлт учруулахгүй байх хэмжээнд барьж байхад оршино⁴.

Энэхүү “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” конвенци нь хүрээлэн буй орчинд зайлшгүй шаардлагатай тулгамдаад байсан асуудлыг шийдэхэд үндсэн суурь акт болсон юм. Уур амьсгалын өөрчлөлтийн конвенциор улс орнуудын хүлээсэн үүрэг нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд хангалтгүй байсан тул 1995 оны Берлинд болсон конвенцид оролцогч талуудын анхдугаар Бага хурлаас гаргасан “Берлиний мандат”-аар аж үйлдвэржсэн орнуудын хүлээх үүргийг илүү тодорхой, хатуу болгох асуудлыг шийдвэрлэх хэлэлцээрийн шинэ үе шат эхлэх нь зүйтэй гэж үзсэн. Энэ шийдвэрийн дагуу боловсруулсан Протоколыг Япон улсын Киото хотноо болсон талуудын 3 дугаар Бага хурлаар хэлэлцэн “Киотогийн Протокол” хэмээн нэрлэж 1997 оны 12 дугаар сарын 11-нд баталсан байна.

НҮБ-ын гишүүн 100 гаруй орны төр засгийн тэргүүн оролцсон Даян дэлхийн тогтвортой хөгжлийн их чуулган 2002 оны 9 дүгээр сард Өмнөд Африкийн Йоханнесбург хотноо болжээ. Уг чуулган 1992 онд Рио-д болсон дэлхийн дээд хэмжээний уулзалтаар баталсан Даян дэлхийн XXI зууны хөгжлийн хөтөлбөрийн сүүлийн арван жилийн хэрэгжилтийг дүгнэж цаашдын зорилтыг тодорхойлж тогтвортой хөгжлийн талаарх “Йоханнесбургийн тунхаглал”, “Хэрэгжүүлэх төлөвлөгөө” гэсэн үндсэн 2 баримт бичгийг батлан гаргажээ. Эдгээр баримт бичигт даян дэлхийд тулгарч буй асуудлыг тэмдэглэхдээ: “Дэлхийн хүрээлэгч орчин үргэлжлэн доройтсоор байна. Биологийн төрөл зүйл үргэлжлэн хорогдож, загасны нөөц үргэлжлэн багасч, үржил шимтэй газар улам улмаар цөлжилтөд автаж, цаг уурын өөрчлөлтийн сөрөг үр дагавар хэдийнээ тодорхой болж, байгалийн гамшгийн давтамж, сүйтгэл улам ихсэж, хөгжиж буй орон улам эмзэг болж агаар, ус далайн бохирдол сая сая амьд ертөнцийг үргэлжлэн хөнөөсөөр байна” гэжээ. Дэлхий ертөнцийн экологийн ерөнхий төлөв XXI зууны эхэнд ийм байна. Цаашид яах вэ? гэдэгт Йоханнесбургийн чуулган хариу болгон гаргасан тунхаглал хэрэгжүүлэх төлөвлөгөөний нэг гол зарчим бол Рио-Де-Жанейрогийн Тунхаглалын 7 дугаар зарчмыг баримтлан олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжил, хүрээлэн буй орчны хамгаалал гэсэн хоорондоо харилцан хамаарал бүхий бие биеэ харилцан тэтгэх тулгуур болох тогтвортой хөгжлийн гурван бүрдэл хэсгийг интеграцчилах явдлыг дэмжихэд орших ажээ.

Энэхүү уулзалтын гол зорилго нь дэлхий нийтээрээ тогтвортой ирээдүйд хүрэх, хүн төрөлхтөнд хүрээлэн буй орчиндоо хор хөнөөл учруулалгүйгээр өөрсдийн хэрэгцээг хэрхэн хангах арга замыг зааж өгөхөд чиглэгдэв.

Йоханнесбургийн Тунхаглалд “Бидний гарал үүслээс ирээдүй хүртэл”, “Стокгольмоос Рио-де-Жанейро-гоор дамжин Йоханнесбург хүртэл”, “Бидэнд тулгарч буй асуудлууд”, “Тогтвортой хөгжлийн талаарх бидний амлалт”, “Олон талт байдал, бидний ирээдүй” гэсэн ангилал бүхий 37 зүйл хөтөлбөр, амлалтыг тусган тодорхойлжээ⁵. Тэдгээрийн гол агуулга нь товчдоо амьдралын бүхий л

⁴ Л. Нацагдорж, П. Батима. Уур амьсгалын өөрчлөлт. УБ., 2002 он, 9 дэх тал

⁵ П.Очирбат, Ш.Баясгалан, Б.Чинзориг. Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ., 2004, 40 дэх тал

туршлагыг өвөртлөн дэлхийн өнцөг булан бүрээс хүрэлцэн ирсэн төр, засаг, олон нийтийн зүтгэлтэн бүгдээрээ орон нутаг, үндэстэн, бүс нутаг, дэлхийн түвшинд эдийн засаг, нийгмийн хөгжил, хүрээлэн буй орчныг хамгаалах гэсэн тогтвортой хөгжлийн харилцаа уялдаа бүхий, харилцан тэтгэх тулгуурыг сайжруулан бэхжүүлэх нь хамтын хариуцлага гэж санал нэгтэй үзсэнд оршино.

XXI зуунд Даян дэлхийн хөгжлийн чиг хандлага, стратегийг тодорхойлсон гурван үндсэн баримт бичгийг дэлхийн бүх орнуудад баримталж байгаагийн нэг нь Рио-Де-Жанейрогийн Тунхаглал, хоёрдох нь Мянганы Тунхаглал, гуравдахь нь Иоханнесбургийн Тунхаглал, хэрэгжүүлэх төлөвлөгөө юм. Эдгээр баримт бичгүүд нь цаг хугацаа, хамрах хүрээний хувьд ялгаатай боловч үндсэн агуулга нь тогтвортой хөгжлийн тулгын гурван чулуу болох эдийн засгийн, экологийн, нийгмийн хөгжлийг хангах зорилт юм.

Киотогийн протокол

Уур амьсгал цочмог өөрчлөгдөж, үер, ган, зуд, хуурайшил, салхи, шуурга зэрэг байгалийн онц үзэгдлийн давтамж ихэсч байгаа нь дэлхийн дулаарлаас үүдэлтэйг эрдэмтэд тогтоогоод даруй хорь гаруй жил болж байна. Даян дэлхийн дулаарлын гол буруутан нь өндөр хөгжсөн орнуудын үйлдвэр, уул уурхай, газар тариалан, хог хаягдал, авто машины утаанаас ялгарч буй хүлэмжийн хий гэж нэрлэгдэх болсон агаар бохирдуулагч бодисууд юм.

1997 онд батлагдсан Киотогийн протоколын гол зорилго нь 2000 оноос хойшхи хугацаанд агаар дахь хүлэмжийн хийн хэмжээг бууруулах асуудлыг улс орнуудын хувьд үүрэг болгон өгсөн явдал юм.

Тус протоколд хүлэмжийн хийг бүрдүүлж байгаа хорт хий болох нүүрсхүчлийн хий, метан, азотын хүчил, ус фторт нүүрстөрөгчүүд, перфторт нүүрстөрөгчүүд, гексафторт хүхэр “А” хавсралтанд хамааруулж мөн салбар эх үүсвэрүүдийг тодорхойлон оруулсан байна. “В” хавсралтыг гаргаж түүндээ 1990 оноос хойшх хүлэмжийн хийн 55-аас доошгүй хувийг гаргагч хөгжингүй улс орнуудыг жагсааж тухайн орнуудын хүлэмжийн хийн ялгаралтыг тоон дүнгээр гарган оруулжээ. Ингэж гаргасны ач холбогдол нь тухайн орнууд болон бусад орнуудын хувьд тоон үзүүлэлтээс дээш хүлэмжийн хийг гаргахгүй ялгаралтыг барих болон багасгах, цаашилбал 1990 оны түвшнөөс 5 хувиар багасгах зорилт тавьж, хүлэмжийн хийг тогтворжуулах үүргийг хүлээж байгаа юм⁶.

Уг протоколын 2 дугаар зүйлд тогтвортой хөгжлийг хангах зорилгоор олон чухал заалтууд орсон байна. Тухайлбал, елс орнууд эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийнүүдийн шингээгч, хадгалагч эх үүсвэрүүдийг хамгаалах, нэмэгдүүлэх, ойжуулалт, ойг нөхөн сэргээх болон хөдөө аж ахуйн үр ашигтай тогтвортой хөгжлийн арга хэмжээг хөхүүлэн дэмжих, эрчим хүчний шинэ технологи нэвтрүүлэх, нүүрсхүчлийн хийг шингээгч технологи нэвтрүүлэх, боловсруулах, хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, конвенцийн зорилгод харш хүлэмжийн хийн хаягдлын эх үүсвэр болох бүх салбарын зах зээлийн боловсронгуй биш байдлыг тууштай бууруулах буюу бүрэн арилгах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн урамшуулал, татвар хураамжаас чөлөөлөх зэрэг зах зээлийн арга механизмыг хэрэглэх, хүлэмжийн хийн ялгаралтыг хязгаарлах, бууруулахад

⁶ <http://unfccc.int>

чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх явдлыг дэмжих зорилгоор холбогдох салбаруудын шаардлагатай өөрчлөлтийг хөхүүлэн дэмжих, тээврийн салбарт хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, хязгаарлахад чиглэсэн арга хэмжээг авах гэх мэт маш чухал заалтууд оржээ.

Мөн протоколын 3 дугаар зүйлийн 2-т уг конвенцид элсэн орсон орнууд 2005 оны үе гэхэд энэхүү Протоколоор хүлээж байгаа үүргээ биелүүлэхэд мэдэгдэхүйц ахиц гаргасан байна гэж заажээ.

2005 оны 2 дугаар сарын 16-нд Киотогийн протокол албан ёсоор мөрдөгдөж эхэлсэн юм. Уг протокол мөрдөгдөж эхэлснээр дэлхийн зах зээлд уг протоколын 6 дугаар зүйлд зааснаар “хүлэмжийн хий” гэгч шинэ бараа худалдагдаж эхэлсэн. Энэ чухамдаа улс орнууд өөрийн хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээг бууруулсан⁸ зааж өгсөн тоо хэмжээнээс багасгаж чадсан, хүлэмжийн хийн шингээгч механизмыг бүрдүүлсэн бол илүүдэл хүлэмжийн хийн нормоо бусдад худалдах юм уу худалдаж авна гэсэн үг юм. Жишээ нь: Хятад, Япон гэх мэт улсуудад томоохон үйлдвэрүүд өөрийн нормын хүлэмжийн хийг гаргасан бол бусад үйлдвэрүүдийн хүлэмжийн хийн нормоос худалдаж авч үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна⁷.

Киотогийн протоколын дагуу хөгжсөн орнууд хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах үүрэг хүлээж байгаа бөгөөд 2008-2012 он гэхэд дээрх бохир хийнүүдийн ялгаралтыг 1990 оны түвшинд хүртэл бууруулж “халсан дэлхийг буцааж хөргөх” зорилго тавьж байна. Үүний тулд хүлэмжийн хийг өөр хоорондоо зах зээлийн үнээр худалдах, хүлэмжийн хийг бууруулах хамтарсан төсөл хэрэгжүүлэх болон хөгжиж байгаа орнуудад хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлт оруулах, шилжүүлэх замаар шийдэх юм. 2012 онд уг протоколын хүчинтэй хугацаа дуусах юм.

2007 оны 11 дүгээр сард Киотогийн Протоколын хүрээнд хуралдсан хуралдаанаас харахад 178 улс уг протоколд элсээд байсан бөгөөд хуралдаанд ирсэн улсуудаас АНУ болон Казакстан улсууд л уг протоколд гарын үсэг зурахаас татгалзсан юм. АНУ-ын татгалзах болсон шалтгаан нь уг актад заасан хүлэмжийн хийг жил тутам бууруулах хувь хэмжээг зөвшөөрөөгүй бөгөөд ихэнх хүлэмжийн хийг гаргагч томоохон үйлдвэрүүддээ өөрчлөлт хийхэд асар их хөрөнгө мөнгө шаардагдах учраас татгалзах болсон. Киотогийн протоколын нэг чухал зүйл нь дэлхийн улс орнуудыг бүс нутаг, улсуудаар нь хуваан авч үзэж хүлэмжийн хийг жил жилд бууруулах хувь хэмжээг өөр өөрөөр зааж өгснөөрөө ач холбогдолтой юм. Хүн төрөлхтний тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх томоохон алхмын нэг нь Киотогийн Протокол, түүний хэрэгжилт юм⁸.

Манай улсын хувьд тогтвортой хөгжлийн хөтөлбөрөө 1998 онд боловсруулан гаргаж мөрдөж хэрэгжүүлж эхэлсний хүрээнд 1999 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Киотогийн Протоколд элссэн 19 дэх орон болсон юм⁹. Уг актад элссэнээр манай улсын хувьд шинжлэх ухаан, техникийн тэргүүний ололт бүхий өндөр өртөгтэй технологийг хөрөнгө зардалгүйгээр, бохир хийн ялгарлаа багасгах замаар хүлээн авч, энэ үйл ажиллагаанд оролцох боломжийг уг протокол нээж байгаа гэсэн үг. Хоцорсон технологитой үйлдвэр, аж ахуйн нэгжтэй бидний хувьд энэ бол алтан боломж юм.

⁷ <http://indeco.com/kyoto>

⁸ http://ec.europa.eu/environment/climat/home_en.htm

⁹ http://en.wikipedia.org/wiki/List_of_Kyoto_Protocol_signatories

Дэлхий нийтээрээ нэгдэн нийлж тогтвортой хөгжлийн зүг тэмүүлэх их үйлсэд Киотогийн Протоколын ач холбогдол, гүйцэтгэх үүрэг, хэрэгжилт ихээхэн тус нэмрийг авчрах юм.

Ном зүй

1. М.Дүгэрсүрэн, О.Хосбаяр. Олон улсын эрх зүй. УБ., 1999 он.
2. Монгол улсын Тогтвортой хөгжил” төсөл хэрэгжүүлэх алба. “Хүрээлэн Буй Орчин, Хөгжил”. Рио-де-Жанейрогийн Тунхаглал.
3. Л. Нацагдорж, П. Батима. Уур амьсгалын өөрчлөлт. УБ., 2002 он.
4. П.Очирбат, Ш.Баясгалан, Б.Чинзориг. Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ., 2004.
5. **Website**
6. <http://unfccc.int>
7. <http://indeco.com/kyoto>
8. http://ec.europa.eu/environment/climat/home_en.htm
9. http://en.wikipedia.org/wiki/List_of_Kyoto_Protocol_signatories